

## **Ерөнхий мэргэжлийн эмчийн мэргэжлээр эмчлэх зөвшөөрөл олгох шалгалтын жишиг сорил**

### **Хувилбар -11**

1. Нэг сонголттой тест ( Зөвхөн 1 хариулт зөв байх ) Энэ хэлбэрийн сорил нь А, В, С, D, E гэсэн дугаартай бөгөөд Зөвхөн 1 зөв хариуг сонгоно.
  2. Олон сонголттой тест ( Хэдэн ч хариулт зөв байж болох )
    - 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол (A.)
    - 1 ба, 3 дугаар хариултууд зөв бол (B.)
    - 2 ба 4 дугаар хариултууд зөв бол (C.)
    - Зөвхөн 4-р хариулт зөв бол (D.)
    - Бүх хариулт зөв бол (E.)
  3. Шалтгаан хамаарлын тест (Заагдсан тестүүдийн үнэн зөв хийгээд тэдгээрийн шалтгаан хамаарлыг тодорхойлно.)
    - Зөв, Зөв, Зөв (A.)
    - Зөв, Зөв, Буруу (B.)
    - Зөв, Буруу, Буруу (C.)
    - Буруу, Зөв, Буруу (D.)
    - Буруу, Буруу, Буруу (E.)
- /1./ Милиар сүрьеэгийн үед уушгинд гарах голомтот сүүдрийн онцлог
- A. Жижиг, нэг хэвийн
  - B. Уушгины оройд, янз бүрийн хэмжээтэй
  - C. Уушгины нийт талбайд, янз бүрийн хэмжээтэй
  - D. Уушгины оройд 6 мм хүртэл хэмжээтэй
  - E. Уушгины талбайн доод хэсэгт 6 мм хүртэл хэмжээтэй
- /2./ Сүрьеэгий микобактерээр хүн халдварлах үндсэн зам бол
- A. Арьсаар
  - B. Хүнсээр
  - C. Ихсээр
  - D. Агаар-дуслаар
  - E. Салстаар
- /3./ 10 сарын эхээр танай эмнэлэг дээр томуугийн H1N1 хэв шинжийн халдвар дэгдсэн. Тухайн үед H3N2-ын вакцин хийх боломжтой байна. Эмнэлгийн ажилчид, өвчтөнг хамгаалах зорилгоор ямар арга хэмжээ авах вэ?
- A. Эмнэлгийн эмч, ажилчдад шинжилгээ хийж, зөвхөн H1N1-н эсрэг биеийн титр өндөр байгаа хүмүүсийг дэгдэлт намдтал ажиллуулна.
  - B. Байгаа вакциныг хийнэ
  - C. H1N1-н халдвар авсан байж болох эмч, эмнэлгийн ажилчдад маск, нүдний шил зүүлгэх арга хэмжээ авна
  - D. Эмнэлгийн нийт эмч, ажилчдад амантадин\ремантадин\ уулгаж, тохирох вакциныг хийсний дараа 2 долоо хоног үргэлжлүүлэх
  - E. Эмнэлгийн эмч, нийт ажилчдад 23-валентын пневмококкийн вакцин хийхийг зөвлөнө. Учир нь томуугийн A вирусын халдвартай өвчтөнд хамгийн элбэг тохиолддог халдвар бол S.pneumoniae байдаг
- /4./ Багтраат байдлын хүндийн зэрэг дараах шинжээр тодорхойлогоно:
- A. Багтралын үргэлжлэх хугацаа
  - B. Хуурай хэржигнүүрийн тоо болон интенсивность багасах
  - C. Стридор амьсгал бий болох
  - D. Ухаан алдагдах
  - E. Гипокси ба гиперкарниийн зэрэг
- /5./ Зүүн уушгини доод хилийг олохдоо ямар шугамаар тогших вэ?
- A. Өвчүүний ойролцоо
  - B. Эгэмний дунд
  - C. Суганы \урд, дунд, ард\
  - D. Далны

E. Нурууны ойролцоо

/6./ Уушгины архаг бөглөрөлт өвчтэй хүнд дараах үзүүлэлт нэмэгдэнэ:

1. Амьсгалын эзлэхүүн
2. РаCO<sub>2</sub>
3. Уушгины амьдралын багтаамж
4. Уушгины үлдэгдэл агаарын эзлэхүүн
5. МВЛ

/7./ Гялтангийн хөндийд цусархаг шингэн хурах шалтгааныг нэрлэнэ үү.

1. Уушгины хавдар
2. Уушгины артерийн бүлэнт бөглөрөл
3. Уушгины сурьеэ
4. Цээжний гэмтэл
5. Гепарин эмчилгээ

/8./ Уушгины архаг бөглөрөлт өвчний оношийг дараах шинжүүдийн үндсэн дээр сэжиглэж болно:

1. Тогтвортой амьсгаадаа, цээж шуугих, ханиаж, цэр гарах
2. Удаан хугацаанд тамхи татсан байх
3. Өвчин аажим даамжрах
4. Өвчтөн 50-иас дээш настай байх
5. Гуурсан хоолой бөглөрөх шинж бүрэн арилахгүй байх

/9./ Уушгины үрэвслийн нийтлэг бус үүсгэгч юу вэ?

1. Микоплазм
2. Легионелл
3. Хламиди
4. Томуугийн вирус
5. Цитомегаловирус

/10./ Гялтангийн хөндийд бага хэмжээний эсвэл уутлагдсан шингэн сэжиглэсэн тохиолдолд мар шинжилгээгээр оношийг батлах вэ?

1. Цээжний хэт авиан шинжилгээ
2. Цээжний рентген зураг
3. Цээжний компьютерт томограмм
4. Олон барлалд тогшилт, чагналт хийх
5. Ажиглах

/11./ Нефроны аль хэсэгт натрийн ихэнх хувь нь эргэн шимэгддэг вэ?

- A. Ойрын тахир сувганцарт
- B. Генлийн гогцооны өгсөх хэсэг
- C. Холын тахир сувганцарт
- D. Цуглуулах сувганцарт
- E. Түүдгэнцэрт

/12./ Артерийн гипертензийн нефропатийн эрт үед шээсэнд гарах өөрчлөлт

- A. Лейкоцитури
- B. Микроальбуминури
- C. Протейнури+гематури
- D. Оксалатури
- E. Гипостенури

/13./ Бөөрний архаг өвчний 3-р үед ТШХ яаж өөрчлөгдхөх вэ?

- A. ТШХ бага зэрэг буурсан 60-89 мл/мин
- B. ТШХ бага зэрэг буурсан 30-60 мл/мин
- C. ТШХ буурсан 30-59 мл/мин
- D. ТШХ буурсан 30-49 мл/мин
- E. ТШХ маш их буурсан 15-29 мл/мин

/14./ Хүүхэд шөнө орондоо шээхийг юу гэж нэрлэх вэ?

- A. Олигоури
- B. Дизури
- C. Никтури
- D. Странгури

Е. Энурез

/15./ Гликокаликс гэж аль ойлголтыг нэрэлдэг вэ

- A. Подоцитийн элемент
- B. Мезангиумын элемент
- C. Суурин мембрани хасах цэнэгтэй хэсгүүд
- D. Ялгаруулах аппарат
- E. Ренин

/16./ Бөөрний цочмог дутагдлын үед Гемодиализ хийх заалт

- 1. Цусны креатинин 600 мкмоль/л-ээс ихсэх
- 2. Цусны Кали 6,5 ммоль/л ихсэх
- 3. Уушиг тархинд хаван үүсч эхлэх
- 4. .2-3 хоног эмчилгээ хийхэд үр дүнгүй бол
- 5. Биеийн ерөнхий байдал маш хүнд байх

/17./ Соронзон Резонанс Томографи шинжилгээгээр бөөр шээс дамжуулах замын юуг судлах вэ?

- 1. Бөөрний байрлал болон бүтэц
- 2. Бөөрний цусан хангамж
- 3. Бөөрний хавдар
- 4. Бөөрний чулуу
- 5. Бөөрний уйланхай

/18./ Шээсний нянгийн шинжилгээд дараах аргууд орно

- 1. Зимницийн сорил
- 2. Бактерлогийн шинжилгээ
- 3. Бензолын сорил
- 4. Нитритийн сорил
- 5. Преднизолоны сэдээх сорил

/19./ Бөөрний цочмог дутагдлын үед зайлшгүй хийх шинжилгээг нэрлэнэ үү?

- 1. Цусан дах креатинин
- 2. Цусны PH үзэх
- 3. Цусны электролит үзэх
- 4. Зимницийн сорил
- 5. Шээсэн дэх давсны агууламж

/20./ Архаг гломерулонефритийн үед гормон эмчилгээ хийх заалт

- 1. Гематури
- 2. Артерийн даралт ихсэлт
- 3. Бөөрний архаг дутагдал
- 4. Нефроз хам шинж
- 5. Сэдрэлээс сэргийлэх зорилгоор

/21./ Нефроз хам шинжийн үед цусанд липид холестерины хэмжээ эрс ихэссэн байдаг . Үүнтэй холбоотой өвчтөний БЖИ маш их ихэссэн, хаван ч бас их байдаг.

/22./ Өвчтөн Л. эр, 28 настай хавагнан, шээсний шинжилгээнд протеинури 3,75г/л, Рентген шинжилгээнд архаг остеомиелит илэрсэн байлаа. Уг өвчтөнд гломерулонефрит онош тавиад кортикостеройд эмчилгээг эхэлнэ.

/23./ Аль нь элэгний анхдагч хавдрын үед илрэхгүй вэ?

A. Сийвэнгийн церулоплазмин багассаны улмаас мэдрэлийн өөрчлөлт үүсч, чичрэх татах хам шинж, гиперкинез илрэх

- B. Антибиотик эмчилгээнд дарагдахгүй урт хугацаагаар халуурах
- C. Эмнэлзүйн шинж тэмдэг бүдэг байж, архаг гепатит хэлбэрээр явагдах

/24./ APUD тогтолцооны G эс ямар даавар ялгаруулж, физиологийн ямар үүрэг гүйцэтгэх вэ?

- A. Серотонин ялгаруулж, салст ялгаралтыг сайжруулна
- B. Гастрин ялгаруулж, давсны хүчил ялгаралт болон пепсиногеныг идэвхжүүлнэ
- C. Бомбезин ялгаруулж, нойр булчирхайн шүүрлийг идэвхжүүлнэ
- D. Секретин ялгаруулж, давсны хүчил ялгаралтыг саатуулна

- E. Соматостатин ялгаруулж уургийн нийлэгжилтийг saatuulna
- /25./ Барретын улаан хоолой гэж юуг хэлэх вэ?
- A. Улаан хоолойн салстад шарх үүсэх
  - B. Улаан хоолойн салст сорвижих
  - C. У/хоолойн төгсгөл хэсгийн давхраат эпител бортгон хучуураар солигдох метаплази өөрчлөлт
  - D. У/хоолойн төгсгөл хэсгийн давхраат эпител хавтгай хучуураар солигдох дисплази өөрчлөлт
  - E. У/хоолойн төгсгөл хэсгийн давхраат эпител зузаарах өөрчлөлт
- /26./ Дараах эмнүүдийн аль нь нойр булчирхайн шүүрлийг багасгах эм бэ?
- A. Лукулин
  - B. Фестал
  - C. Панкреатин
  - D. Контрикал
  - E. Панкурмен
- /27./ Цөсний чулуу хайлцуулах мэс заслын бус эмчилгээ
- A. Уян дурангаар хийх холецистэктоми ажилбар
  - B. Литотрипси, урсофальк
  - C. Цөсний гэрийг магнезмаар угаах
  - D. Зүү эмчилгээ
  - E. Хоолны дэг баримтлах
- /28./ Цөсний хатгааны үеийн шинжийг сонгоно уу.
- 1. Өвдөлт баруун хавирганы нумаар
  - 2. Хэвлийд тэмтрэлтээр үүсгэвэргүй
  - 3. Өвдөлтийн үргэлжлэх хугацаа >3 цаг
  - 4. Аюулхайд өвдөнө
  - 5. Амилаза ихэсч болно
- /29./ Үйл ажиллагааны гаралтай өтгөн хаталтын үед хэрэглэх хоол эмчилгээ?
- 1. Машинсан махтай хоол, давс багатай
  - 2. Рашаан уух, махан хоол
  - 3. Цагаан идээ, сүү, жимс
  - 4. Хивэг, ургамлын эслэгээр баялаг хоол хэрэглэх
  - 5. Шөлтэй хоол, мөөг, загас
- /30./ Шингэний зохицуулагад аль даавар нь ходоод saatuulagч фермент болох вэ?
- 1. Мотилин
  - 2. Пептид
  - 3. Соматостатин
  - 4. Дуокрин
  - 5. ВИП
- /31./ Улаан хоолойн тархмал агшилтыг үүсгэх хоёрдогч шалтгаануудыг сонгоно уу?
- 1. Ходоод улаан хоолойн сөөргөө өвчин
  - 2. Улаан хоолойн үрэвсэл
  - 3. Өрцний ивэрхий
  - 4. Ходоод дээд гэдэсний шархлаа өвчин
  - 5. Цөсний чулуу
- /32./ Улаан хоолойн булчинлаг бүрхүүл нь хэдэн см зузаантай вэ?/
- 1. 0.7 см
  - 2. 1.5 см
  - 3. 1.0 см
  - 4. 2.0 см
  - 5. 2.5 см
- /33./ Элгэн дэх холестазын үед цөсний хүчлийн нийлэгжилт сулардаг. Учир нь элэгний эс гэмтэж цөсний үндсэн бүрэлдэхүүн хэсэг болох холестерины нийлэгжилтийн дутагдал болдог.

/34./ Бүдүүн гэдэсний үрэвслийн үед нянгийн бичил орчинг хэвийн болгох зорилгоор Лактобактериньг З хүн тунгаар уулгах ба нэг курс эмчилгээ нь 2-3 жил үргэлжилнэ.

/35./ Гипокортицизм үүсгэх үндсэн шалтгааныг нэрлэнэ үү.

- A. Сүрьеэ
- B. Глюкокортикоид өндөр тунгаар хэрэглэх
- C. Гипофизийн базофиль эсийн хавдар
- D. Феохромоцитома
- E. Кортикостерома

/36./ Гипогликемийн комын үед авах арга хэмжээг нэрлэ

- A. Амаар чихэртэй ус уулгах
- B. Инсулин эмчилгээ
- C. 0,9% NaCl уусмал
- D. 40% глюкозын уусмал
- E. Хөдөлгөөн хорих

/37./ Гиперкортицизмын эмнэл зүйн шинж

- A. Биеийн жин буурах
- B. Булчингийн сулрал
- C. Нимгэн цайвар язрал
- D. Цагаан шаргал царай
- E. Полименоррэй

/38./ Ямар үед бамбай булчирхайн 1-р зэргийн томрол гэх вэ?

- A. хажуугийн эрхтнээ дарсан
- B. нүдэнд харагдана
- C. нүдэнд харагдана, тэмтрэгдэнэ
- D. тэмтрэгдэнэ, харагдахгүй
- E. тэмтрэгдэхгүй, харагдахгүй

/39./ Хэвийн буюу эрүүл биеийн жингийн тухай ойлголт хэзээ бий болсон бэ?

- A. XIX зууны сүүл үе
- B. XX зууны эх
- C. XX зууны 30-аад он
- D. XX зууны 40-өөд он
- E. XX зууны 50-аад он

/40./ ЧШ-ийн бусад хэлбэрийн үеийн шалтгаан.

1. β-эсийн деструкци
2. β-эсийн гаж хөгжил
3. Инсулины дөжрөл
4. Эндокринопати
5. Жирэмсэн үед цусанд глюкоз ихсэх

/41./ Таргалалтын үед хэрэглэдэг хүлээн зөвшөөрөгдсөн эмийн бэлдмэл

1. Дексфенфлюрамин
2. Фенолфталеин
3. Сибутрамин
4. Орлистат
5. Парлодел

/42./ Остеопорозын эрт оношлогоонд ясны зураг авах рентген шинжилгээ ач холбогдолтой. Учир нь яс жингээ 30-50% алдсан үед ясны зураг авах рентген шинжилгээгээр остеопороз оношлогддог.

/43./ Синкопийн эмнэл зүйн шинж тэмдэгийн онцлогийг тэмдэглэнэ үү?

- A. Шинж тэмдэг нь гэнэт эхэлж, удаан үргэлжилдэг
- B. Гэнэтийн эхлэл, богино хугацааны үргэлжлэл, тархины үйл ажиллагаа бүрэн эргэн сэргэнэ
- C. Гэнэтийн эхлэл, богино хугацааны үргэлжлэл, тархины үйл ажиллагаа бүрэн эргэн сэргэхгүй

D. Аажим эхлэл, богино хугацааны үргэлжлэл, тархины үйл ажиллагаа бүрэн эргэн сэргэнэ

E. Аажим эхлэл, удаан үргэлжлэл, тархины үйл ажиллагаа бүрэн эргэн сэргэнэ

/44./ Өвчтөн 29 настай, эмэгтэйг чагнахад зурхний I цэгт диастолын, II цэгт систолын тод шуугиан сонсогдоно. Зурхний ямар гажиг байх магадлалтай вэ?

A. Митрал хавхлагын ба аортын хавхлагын дутагдал хавсарсан гажиг

B. Митрал хавхлагын дутагдал ба аортын хавхлагын нарийсал хавсарсан гажиг

C. Митрал хавхлагын нарийсал ба аортын хавхлагын дутагдал хавсарсан гажиг

D. Митрал хавхлагын ба аортын хавхлагын нарийсал хавсарсан гажиг

E. Митрал хавхлагын нарийсал ба уушгины хавхлагын дутагдал хавсарсан гажиг

/45./ Зурхний шигдээсийн үед анхны яаралтай тусламжийг MONA гэдэг схемээр үзүүлдэг.

Энэ нь ямар үгсийн товчлол вэ?

A. Морфин, хүчилтөрөгч, нитрат, антикоагулянт

B. Морфин, хүчилтөрөгч, нитрат, антиагрегант

C. Морфин, хүчилтөрөгч, нитрат, анальгетик

D. Морфин, хүчилтөрөгч, нитроглициерин, аспирин

E. Морфин, хүчилтөрөгч, нитроглициерин, антиаритмитик

/46./ 1 мл гепарини уусмал хэдэн нэгж гепарин байдаг вэ?

A. 5000

B. 1000

C. 10000

D. 15000

E. 1500

/47./ Анхдагч артерийн гипертензийн үед ЗЦБ –р илрэх зүүн ховдлын томролын Лион-Соколовын шинж тэмдэгийг заах

A. Rv5 >25мм

B. Sv3+RavI > 24 мм

C. Rv4>Rv5

D. Rv5+Sv1>30мм

E. Rv5+Sv1>35мм

/48./ Дараах бэлдмэлээс ADP рецепторт хориг тавьж, тромбоцитийн агрегацийг багасгадаг үйлчилгээтэй антиагрегантийг сонгох

1. Клопидогрел

2. Тиклодипин

3. Прасугрел

4. Аспирин

5. Тирофибан

/49./ Дараах эмийн бус эмчилгээнээс аль нь артерийн даралтыг бууруулахад тохиромжтой вэ?

1. Биеийн илүүдэл жинг бууруулах

2. Жимс, ногооны хэрэглээг ихэсгэх

3. Тогтмол дасгал хийх

4. Тамхинаас гаргах

5. Архины хэрэглээг багасгах

/50./ Тодорхой шалтгаангүй тэлэгдлийн кардиомиопати нь ишемийн кардиомиопатигаас юугаар ялгаатай вэ?

1. Залуу хүмүүст илүү тохиолддог

2. Зүрхний цахилгаан бичлэг эмгэг өөрчлөлтгүй байдаг

3. Дөрвөн хөндий тэлэгдэж томордог

4. Ховдол хоорондын таславч зузаардаг

5. Уушгины гипертензи үүсдэг

/51./ Зурхний шигдээсийн ямар хүндрэлийг хэт авиан шинжилгээгээр оношлох боломжтой вэ?

1. Ховдол хоорондын цоорхой

2. Ховдлын бүлэн

3. Ховдлын цүлхэн

4. Тампонад
5. Зүрхний дутагдал

/52./ Халдварт эндокардитын эмнэл зүйн онцлог нь юу вэ?

1. Олон эрхтэн тогтолцоог гэмтээдэг
2. Хүндрэл элбэг, нас баралт өндөр өвчин
3. Цусаар дамжиж, сепсис хэлбэрээр явагддаг
4. Хавхлага гэмтээдэггүй
5. Архаг явцтай

/53./ Хоёр хавтаст хавхлагын гажигтай хүнийг харж ажиглахад "Facies mitralis" илэрдэг. Энэ нь нарийссан нүхээр цус шахагдахдаа хуйларч орсноос болдог.

/54./ Петехи гэдэг нь.....

- A. 5 см болон түүнээс дээш диаметр хэмжээтэй, арьсны тувшиングээс овойгоогүй
- B. Хэмжээний хувьд үзэгний үзүүр төдий олон тооны цусархаг тууралт
- C. Дотор эрхтний гаралтай цус алдалт
- D. 5 см хүртэлх диаметр хэмжээтэй, ихэвчлэн судас тойрон гардаг тууралт
- E. Цустай ханиах, цустай цэр гарах зэрэг амьсгалын эрхтэн системээс илрэх өөрчлөлт

/55./ Ямар өвчний үед сийвэнгийн ферритин багасаж, сийвэнгийн нийт төмөр холбох чадвар ихсэх вэ?

- A. Фолийн хүчил дутагдлын цус багадалт
- B. Архаг цус алдалтын улмаас үүссэн төмөр дутлын ЦБ
- C. Далд хэлбэрийн төмөр дутлын цус багадалт
- D. Вит B12 дутлын цус багадалт
- E. Гипоаплазийн цус багадалт

/56./ Колон сөдөөгч факторын үйлдлийн механизмыг сонгоно уу?

- A. 5 метилтетрагидрофолатаас Тетрагидрофолат үүсгэж эсийн нуклейн хүчлийн нийлэгжилтэнд нөлөөлнэ
- B. Гемийн бүтцэд орж гемоглобины нийлэгжилтийг дэмжинэ
- C. Улаан эсийн JAK2 ферментийг идэвхжүүлж эсийн хуваагдлыг дэмжинэ
- D. Тимиридилат синтеза ферментийн бүрэлдэхүүнд орж эсийн нуклейн хүчлийн нийлэгжилтэнд оролцно

E. Прогениторыг идэвхжүүлж цагаан эсийн дүрст элементийн хөгжлийг хангана

/57./ Архаг миелолейкоз эмгэгийн үед захын цусны шинжилгээнд голчлон илэрдэг өвөрмөц өөрчлөлтийг сонгоно уу

- A. Гумпрехтийн сүүдэр
- B. Базофиль-эозинофилийн холбоо
- C. Лейкемийн цонх
- D. Улаан эс нулимсны дусал хэлбэртэй болох
- E. Өрсөн зоосны шинж

/58./ Цусны хурц хавдарын ид үедээ оношлогдсон залуу насны хүнд ямар хими эмчилгээ сонгох вэ?

- A. Засралд хүргэх (индукуц)
- B. Засралыг бэхжүүлэх (консолидац)
- C. Засралыг барих (поддержание)
- D. Гидреа өндөр тунгаах өгөх
- E. Монохими эмчилгээ хийх

/59./ Аутоиммун тромбоцитопени үед шинжилгээнд гарч болох өөрчлөлтүүдийг нэрлэнэ үү?

1. Цусны түрхцэнд хэлбэр, хэмжээ нь өөрчлөгдсөн тромбоцит харагдана
2. Цусны бүлэнгийн агчих чадвар муудна.
3. Иммунологийн шинжилгээнд Ig G-ын түвшин өндөр байна.
4. Ясны хэмийн шинжилгээнд мегакариоцит алга болсон байна.
5. Ясны чөмөгний эдийн шинжилгээнд эсжилт буурсан байна.

/60./ Аутоиммуны тромбоцитопени өвчин үүсгэх үндсэн шалтгаануудыг нэрлэнэ үү?

1. Ялтсын үүсэл үр дүнгүй явагдах
2. Ясны улаан чөмгэнд мегакариоцитын үүсэл багасах

- 3. Ялтсын задрал ихсэх
  - 4. Ялтсын мөхлөгүүд цөөрөх
  - 5. Ялтсын үүсэлт удаашрах
- /61./ Жирэмсэн үеийн антенаталь ураг хамгаалал гэж юу вэ?
- A. Жирэмсний 21 долоо хоног дотор
  - B. Жирэмсний 21-36 долоо хоног
  - C. Жирэмсний зөвхөн 37-40 долоо хоног
  - D. Жирэмсний 21 долоо хоногоос төрөх хугацааны ураг хамгаалал
  - E. Төрсний дараах үеийн ураг хамгаалал
- /62./ Цусны эргэлтийн хямралын шинж баруун ховдлын үйл ажиллагааны алдагдлаар тод илэрч буй, хэрлэгийн А II зэргийн идэвхжилтэй, уушигны судасны II зэргийн даралт ихдэлттэй, дөнгөж үүссэн мерцаль хэм алдагдалтай эхчүүд өртөмтгийн хэддүгээр зэрэг хамаарах вэ?
- A. Өртөмтгийн I зэрэг
  - B. Өртөмтгийн III зэрэг
  - C. Өртөмтгийн II зэрэг
  - D. Өртөмтгийн IV зэрэг
  - E. Өртөмтгийн V зэрэг
- /63./ Умайн салстын цочмог үрэвслийн үед илрэх эмнэлзүйн гол шинж тэмдэг юу вэ?
- A. Халуурах
  - B. Сарын тэмдэг хаагдах
  - C. Хэвлэлийн доод хэсгээр хүчтэй өвдөх
  - D. Сарын тэмдгийн мөчлөг байнга алдагдах
  - E. Цусархаг шингэн байнга гарах
- /64./ Депо-ровераг хэрэглэхийг хориглох заалт юу вэ?
- 1. Жирэмсэн
  - 2. Шалтгаан тодорхой бус утрээний цус алдалт.
  - 3. Элэгний эмгэг ба хөхний хорт хавдар
  - 4. Зүрхний цус хомсдох эмгэг
  - 5. Цусны даралт ихтэй ба цус өтгөрөх эмгэгтэй
- /65./ Жирэмсний хяналтын үйл ажиллагаанд хамаарахыг нэрлэнэ үү:
- 1. Хяналтанд эрт хамруулах
  - 2. Эрсдлийн илрүүлэх
  - 3. Жирэмсний явцын хүндрэлээс урьдчилан сэргийлэх
  - 4. Жирэмсний хүндрэлийг эрт илрүүлж эмчлэх
  - 5. Эрхтэн тогтолцооны эмгэгтэй жирэмсэнг амаржих газарт цаг хугацаанд нь хэвтүүлэх
- /66./ Ургийн бүрхүүл хальсны үүрэгийг нэрлэнэ үү?
- 1. Тэжээлийн
  - 2. Амьсгалын
  - 3. Ялгаруулах
  - 4. Үр хөврөлийн усан оршин үүсгэх
  - 5. Цус төлжүүлэх
- /67./ Шулуун гэдэсний цоорхой нь хуниасын дотор ба хуниасын гадна байрласан үед хагалгааны төрлийг заана уу.
- A. Габриэлийн зүсэлт
  - B. Селивановын зүсэлт
  - C. Блинничевын хагалгаа
  - D. Ганн-Маннын хагалгаа
  - E. Борисын хагалгаа
- /68./ Зүрхэн дээр хийгдэх хагалгаа нь юунаас хамаарч үр дүнд хүрэх вэ?
- A. Мэдээгүйжүүлгийг зөв явуулах
  - B. Хагалгааг гэмтэл багатай хийх
  - C. Цусны хөдлөл зүйн эмгэгийг бүрэн засах
  - D. Хагалгааны дараах үр дүнтэй эрчимт эмчилгээ
- /69./ Улаан хоолой гэмтэх үед гарахгүй хүндрэл нь:
- A. Голчийн үрэвсэл

- B. Цус алдалт
- C. Элэгний буглаа

- D. Улаан хоолой сорвижин нарийсах
- E. Цээжний гялтангийн идээт үрэвсэл

/70./ Амьсгалын дутагдалтай өвчтөн бүрт авч хэрэгжүүлдэг арга хэмжээг нь сонгоно уу?

- A. Амилуулах амьсгалуулалт хийнэ
- B. Амны хөндийгээс соруулж цэвэрлэнэ
- C. Өвчтөнд хүйтэн ус уулгана
- D. Өвчтөнийг тохиромжтой (суугаа) байрлалд оруулан, амраана
- E. Аюулхайг бүслэн шахах аргачлал

/71./ Спиронолактоны (Верошпирон) шахмал хэдэн мг-тай байдаг вэ? Асциттай өвчтөнд хэдэн мг-аар уулгаж эхлэх вэ?

- 1. 5 мг-ын шахмал
- 2. 25 мг-ын шахмал
- 3. 1 шахмалаар уулгах
- 4. 100 мг-аар буюу 4 шахмалаар уулгах
- 5. 50 мг буюу 2 шахмалаар уулгах

/72./ Хеморецептор цочирход ямар нейротрансмитор бөөлжилтийн төвд нөлөөлдөг вэ?

- A. Допамин
- B. Серотонин
- C. Гистамин
- D. Холинэрг
- E. Простогландин

/73./ Амьсгал олшрох , мамьсгал давчидах шинжийн ялгаа юу вэ?

- 1. Амьсгал олшрох нь тоолж болдог объектив шинж
- 2. Амьсгал давчидах нь тухайн хүний мэдрэмж тул субъектив шинж
- 3. Амьсгал олширсон хэрнээ давчидахгүй байж болно.
- 4. Амьсгалын тоо олшроогүй хэрнээ өвчтөний амьсгал давчидаж болно
- 5. Амьсгал олширсон боловч хүн зовиур шаналгаагүй байж болно, харин амьсгал давчидах нь ямагт шаналгаатай байдаг.

/74./ Баруун гар огт хөдлөхгүй, тонус, гүний рефлексүүд арилсан. Мэдрэхүй хэвийн.

- A. сулcaa
- B. чангарсанcaa
- C. талсaa
- D. тэнцвэргүйдэл
- E. анестези

/75./ Духны өмнөд атирааны эмгэг

- 1. Жексон таталт
- 2. Нэг мөчний чангарсанcaa
- 3. Нүүр-хэл-мөрнийcaa
- 4. Эпилепсийн бага уналт
- 5. Мэдрэхүйн өөрчлөлт

/76./ Сүрьеэгийн нянгаар зөвхөн халдвартлагдсаныг тодорхойлох шинжилгээний аргыг нэрлэнэ үү?

- A. Цэрний түрхэцийн шинжилгээ
- B. Гэрлийн шинжилгээ
- C. Туберкулины сорил
- D. Цэрний өсгөвөрлөх шинжилгээ
- E. Дээрхи бүгд

/77./ Уушигны голомтот сүрьеэгийн эмнэл зүйн явц голдуу ямар байдаг вэ?

- A. Шинж тэмдэг хурц тод илэрнэ
- B. Шинж тэмдэггүй буюу шинж тэмдэг бүдэг
- C. Ужиг явцтай
- D. Хүндрэлтэй
- E. Дээрхи бүгд

/78./ Анхдагч сүрьеэгийн ерөнхий шинжийг тоочно уу?

1. Бага насны хүүхэд өвчилнө
2. Цусны их эргэлтээр тархах хандлагатай
3. Тунгалгийг голдуу хамарч гэмтэнэ
4. Зөвхөн уушгийг гэмтээнэ.
5. Хурдан эдгэрнэ

/79./ Туберкулем даамжирч, задарсан тохиолдолд илрэх шинжүүдийг тоочно уу?

1. Цэртэй ханиах, цустай ханиах
2. Хордлогын хам шинж тод илрэх
3. Цэрний түрхэц эерэг гарах
4. Цусны шинжилгээнд өөрчлөлт илэрч, СОЭ хурдсах
5. Гэрлийн шинжилгээнд гэмтэлийн хэмжээ томорч, сүүдэр жигд бус болох

/80./ Бруцеллез өвчнөөс сэргийлэх хамгийн үр дүнтэй аргыг сонго.

- A. Өвчтэй хүнийг тусгаарлах
- B. Өвчтэй малыг тусгаарлах
- C. Эрүүл малыг вакцинжуулах
- D. Халдварт авсан хүнийг вакцинжуулах
- E. Эрүүл хүнийг вакцинжуулах

/81./ Вируст С гепатитын эмчилгээнд зайлшгүй шаардлагатай эмийн бэлдмэл

- A. Аскорбины хүчил
- B. Эссенциале Форте
- C. Зовиракс
- D. Ацикловир
- E. Интерферон альфа

/82./ Герпес вирусийн халдвараас сэргийлэх өвөрмөц арга нь аль вэ?

1. Анатоксин
2. Иммунноглобулин
3. Антибиотик
4. Вирусийн эсрэг бэлдмэлүүд
5. Нийлмэл вакцин

/83./ Цочмог цусан суулгын үед эмгэг анатомын ямар өөрчлөлт гарч болох вэ?

1. Салст бүрхүүл улайж үрэвссэн
2. Фибринт өнгөр
3. Шархлаа үүссэн
4. Салст бүрхүүл үхэжсэн, цоорсон
5. Цус алдсан байна

/84./ Ирит, иридоциклитийн үед өвөр арын хоргын шингэнд идээрхэг шүүдэс хуримтлахыг юу гэж нэрлэдэг вэ?

- A. Hypopion
- B. Hyperpion
- C. Hypohaema
- D. Hyperaemia

/85./ Усанд уусдаггүй уургийг нэрлэнэ үү?

1. А-кристаллин
2. Альбумин
3. В-кристаллин
4. Альбуминоид
5. Липоид

/86./ Урсгалын даралт нь ямар үзүүлэлтээс хамааралтай байдаг вэ?

1. Нүдний дотоод даралт
2. Шингэний уусан гарах хурд
3. Эписклерийн венийн судсан дахь даралт
4. Нүдний алимны хэмжээ
5. Нүдний алимны багтаамж

/87./ Ангина гэж юу вэ?

- A. Залгиурын лимфойд эд үрэвсэлт өөрчлөлтөд нэрвэгдэх хэсэг газрын шинжээр илрэх бүх биеийг хамарсан хурц халдвар.

- B. Хөөмийн гүйлсний хурц үрэвсэл
- C. Хөөмийн гүйлсний архаг үрэвсэл
- D. Хөөмий-нармайн гүйлсний хавсарсан халдвар
- E. Залгиурын лимфойд эд үрэвсэлт өөрчлөлтөд нэрвэгдэх хэсэг газрын шинжээр илрэх бүх биеийг хамарсан архаг халдвар.

/88./ Хамрын цус тогтоох хэсэг газрын эмчилгээнүүдийг нэрлэнэ үү

- 1. Хамарт хүйтэн жин тавих
- 2. Хамрын өмнөд чихээс хийх
- 3. Хамрын арын чихээс хийх
- 4. Азотоор хөлдөөх
- 5. Цахилгаан төөнүүрээр түлэх

/89./ Нярай хүүхдэд хөхлөг сэргтэн хөгжөөгүй байдаг (1). Хүүхэд өсөхийн хирээр хүзүү толгойн булчин хөгжиж, толгойгоо дааж ирэхэд хөхлөг сэргтэн хөгжиж ирнэ

/90./ 62 настай малчин эмэгтэй баруун өвдөгрүү хатгуулж өвддөг болсон зовиуртай. Өвдөг ялангуяа шөнийн цагаар их өвддөг. Тэр мал төл авах, хонь түрүүлэх ажил хийдэг ба бээлийгүй гараараа зулбасан малын эхэс хуулдаг байсан гэв. Түүний ээж 78 настайдаа нугасанд сүрьеэгийн хүйтэн буглаатай, өвдөгний сүрьеэтэй байгаад ХӨСҮТ-ийн сүрьеэгийн тасагт 10 жилийн өмнө нас барсан. Нөхөр нь булчирхайн сүрьеэгээр өвчилж, хүзүүний булчирхайнаас идээрхэг шингэн гойжсон тул мэс засал хийлгэж, булчирхайг авахуулсан. Эмэгтэй өөрөө туранхай, хөлрөмтгий, ядрамтгай. Рентген зурагт баруун өвдөгний яс голомтот эмтэрсэн өөрчлөлттэй, эүүн өвдөг остеоартритын шинжтэй. Түүнд ямар эмчилгээ илүү үр дүнтэй вэ?

- A. Антибиотик
- B. Даавар эмчилгээ
- C. Сүрьеэгийн эсрэг эмчилгээ
- D. Аллопуринол эмчилгээ
- E. Гепарин эмчилгээ

/91./ Настан яагаад сүү цагаан эдээ хэрэглэж байх ёстой вэ?

- 1. Хөгшрөлтөөс сэргийлдэг тул
- 2. Сүү цагаан эдээ шингээхдээ настан илүү сайн тул
- 3. Зүрхний тэтэм судасны хомсдлоос сэргийлдэг тул
- 4. Кальцаар баялаг тул ясны сийрэгжилтээс сэргийлдэг тул
- 5. Тархины цусан хангамжийг сайжруулдаг тул

/92./ Настангийн үйл ажиллагааны чадварыг үнэлхэд Карновскийн индекс 100 оноо бол юу гэж үнэлэх вэ?

- A. Эрүүл, зовиургүй, өвчний шинжгүй
- B. Хэвийн үйл ажиллагаа явуулах чадвартай, өвчний ганц нэг шинж илэрсэн.
- C. Маш сул, идэвхитэй дэмжих эмчилгээ шаардлагатай
- D. Үхлүүд, өвчин маш хурдан даамжирч байгаа
- E. Өөрийгөө арчлах чадвар маш муу тул тусгай асаргаа шаарддаг

/93./ Настан яагаад хоолонд сармис хэрэглэж байх нь маш чухал вэ?

- 1. Халдварт өвчнөөс сэргийлэх тул
- 2. Бөөрний үйл ажиллагаанд сайн тул
- 3. Шээс хөөх, хаван бууруулах үйлчилгээтэй тул
- 4. Цус шингэрүүлэх, цусны эргэлтийг сайжруулах, атеросклероз, зүрхний шигдээсээс сэргийлэх үйлчилгээтэй тул
- 5. Хар сүнсийг зайлцуулдаг тул

/94./ Нурууны радиографи шинжилгээ хийх зорилгод нийцэхгүйг заана уу.

- A. Нуруу нугаламын бүтэц, байршил, хэлбэрийг тогтоох
- B. Гажиг илрүүлэх
- C. Гэмтэл илрүүлэх
- D. Нугалам хоорондын дарагдсан мэдрэл илрүүлэх

Е. Нугалам хоорондын мөгөөрсөн хэсгийн өөрчлөлт илрүүлэх

/95./ Үрэвслийн бус шалтгаант үений үрэвсэлд хамаарахгүйг заана уу.

1. Өглөөний хөшингө30 минутаас бага
2. Өвдөлт ихэвчлэн үдээс хойш үргэлжлэх
3. Зөөлөн эдээд хаван үүсэх
4. УЭТХ хэвийн
5. Үений шингэнд цагаан эс 2000 аас бага

/96./ Эрхтэн тогтолцооны хатуурлын оношлогоонд ямар шинжилгээ чухал вэ:

1. ANA
2. AntidsDNA
3. AntiCCP
4. ACA
5. ANCA

/97./ Бөөрөөр шээсний хүчлийн ялгаралтыг багасгаж улмаар гиперурикеми үүсгэдэг эмийн бэлдмэлийг нэрлэнэ шүү.

1. Тиазидууд
2. Никотины хүчил
3. Аспирин бага тунгаар
4. Лазикс
5. Этамбутол

/98./ Архаг явцтай хэрх төст үений үрэвслийн үед хуруунуудын тэнийлгэгч шөрмөснүүд сунаж, болтос талруу гулсаход хуруунууд чигчий хуруу тийш хазайдаг шинжийг юу гэж нэрлэх вэ.

1. Богтосруу гулгах
2. Хунгийн хүзүү
3. Богтосруу ханарах
4. Товчны дэгээ
5. Тендинит

/99./ Ясны сийрэгжилтэнд аль бүлгийн эмийг хэрэглэх вэ:

1. Эстроген
2. Кальцитонин
3. Бисфосфонат
4. DMARDs
5. Аспирин

/100./ Үений үрэвслийн нөхөн төлжилтийн үед үеэр хавдах, ээрүүл хэлбэртэй болох зэрэг шинжүүд илрэх бөгөөд рентгенд үе хоорондын завсан зузаарсан байдаг.

### **Сорилын зөв хариулт**

1-A, 2-D, 3-D, 4-E, 5-C, 6-D, 7-E, 8-E, 9-A, 10-B, 11-A, 12-B, 13-C, 14-E, 15-C, 16-E, 17-E, 18-C, 19-A, 20-D, 21-C, 22-C, 23-A, 24-B, 25-C, 26-D, 27-B, 28-C, 29-D, 30-D, 31-E, 32-D, 33-A, 34-D, 35-A, 36-D, 37-B, 38-D, 39-C, 40-C, 41-D, 42-D, 43-B, 44-D, 45-D, 46-A, 47-E, 48-A, 49-E, 50-A, 51-E, 52-A, 53-C, 54-B, 55-B, 56-E, 57-B, 58-A, 59-A, 60-B, 61-D, 62-B, 63-C, 64-E, 65-E, 66-D, 67-B, 68-C, 69-C, 70-D, 71-C, 72-A, 73-E, 74-A, 75-A, 76-C, 77-B, 78-A, 79-E, 80-C, 81-E, 82-D, 83-A, 84-A, 85-A, 86-B, 87-A, 88-E, 89-A, 90-C, 91-D, 92-A, 93-D, 94-D, 95-C, 96-D, 97-E, 98-C, 99-A, 100-A,